## “ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Дугаар17 “ГТХЗНТ” УТҮГ

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 10 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

| Нэгжийн нэр | Төлөвлөсөн ажил | Үүнээс | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | - | |
| ЗСХ | 7 | 6 | - | 1 | - | - | - | - | 95.71 |
| ТНУАСХ | 19 | 16 | - | 1 | - | 1 | - | 1 | 89.47 |
| ГХБАБМХ | 10 | 9 | - | - | - | - | - | 1 | 90.00 |
| **Дүн** | **36** | **31** | **-** | **2** | **-** | **1** | **-** | **2** | **90.83** |

**Дүгнэлт**

1. Нэгжүүд 2023 оны 10 дугаар сард нийт төлөвлөсөн 36 ажлаас 86 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 14 хувийг хэрэгжүүлж дуусаагүй (үүнд: 5 ажил) байна.
2. Тайлант сард нийт 36 өргөдөл хүсэлт, хариутай албан бичиг ирснээс 7 өргөдөл хүсэлтэд албан бичгээр хариу өгсөн шийдвэрлэсэн байна.

**Санал зөвлөмж**

1/ Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2 дахь арга хэмжээний 4-р улирлын зорилтот түвшинтэй уялдуулж 11, 12-р сарын ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх. Үүнд: Зурмагийн тасалдалд 4, 2023 оны зуны нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах талаар суурь бүтцүүдэд албан даалгавар өгч биелэлтийг хангуулах.

2/ Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3 дахь арга хэмжээний хүрээнд нэгдсэн зурмагийн хэрэгжилтийн дүнгийн хурал зохион байгуулах.

| | |
|---|---|
| 3. Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн хурлаар 6 өргөдөл хүсэлтийг хэлэлцэж ЗТХЯ-нд уламжилсан бөгөөд ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж дэмжсэн буюу шийдвэрлэгдэх шатанд 14 өргөдөл хүсэлт, шийдвэрлэх хугацаа болоогүй 9 өргөдөл хүсэлт тус тус байна. | 3/ Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4 дэх арга хэмжээний хүрээнд эзэмшлийн болон түрээсийн вагоны ашиглалтыг сайжруулах, суурь бүтэц хоорондын гэрээний биелэлтийг хангах чиглэлээр “БТЕГ” ХХК болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нартай хамтран арга хэмжээ зохион байгуулах. |
| 4. Сайдын шуурхай хуралдаанаас төвд 9 үүрэг даалгаврыг өгсөн бөгөөд биелэлт 83.3 хувийн хэрэгжилттэй байна. | 4/ Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.4, 2.5-д тусгагдсан туршилтын арга хэмжээг үр дүнд хүргэх (ST LIS3DH, FMB640). |
| 5. Захирлын шуурхай зөвлөгөөн 2023.10.31-ний өдөр зохион байгуулагдаж нэгж, ажилтнуудад 18 үүрэг даалгавар өгөгдсөн ба хэрэгжилтийг 2023.11.10-ны дотор тайлагнана. | 5/ Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэх ажлыг үр дүнд хүргэх.<br><br>6/ Нэгж, ажилтнууд “ГТХЗНТ” УТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацаагаар оновчтой зөв төлөвлөх.<br><br>7/ Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 8.6, 8.8, 8.9-д туссан<br>- АХХ-ийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу хөтлөх<br>- Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,<br>- Хэрэглээний хууль тогтоомжийн эрх зүйн мэдлэг олгох, бататгах болон бусад сургалтыг зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн зорилтот түвшинд бүрэн хүргэх.<br><br>8/ Дараах хугацаатай тайлан мэдээллийг ЗТХЯ-нд тайлагнах бэлтгэлийг хангах, тайлагнах. Үүнд:<br><br>а) ЗТХЯ-ны БТГ-ын 2023.02.07-ны 04/599 тоотоор ирсэн сайдын 01 дүгээр албан даалгавар.<br><br>б) ЗТХЯ-ны ТНБД-ын 2023.03.20-ны өдрийн 03/1218 тоотоор ирсэн Зам, тээврийн салбарын |

үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах төлөвлөгөө.

в) ЗТХЯ-ны СХГ-ын 2023.03.21-ний 13/1248 тоотоор ирсэн салбарын ХАБЭА-н салбар хорооны төлөвлөгөө /2023.12.01-ний дотор/.

г) ЗТХЯ-ны БТГ-ын 2023.04.03-ны 04/1474 тоотоор ирсэн сайдын 02 дугаар албан даалгавар.

д) ЗТХЯ-ны СХГ-ын 2023.04.17-ны 13/1739 тоотоор ирсэн Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх тухай 07/01 дугаартай албан даалгавар.

е) ЗТХ-ийн Дэд сайдын 2023.04.26-ны “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02/1904 тоот.

ё) ЗТХЯ-ны БТГ-ын 2023.05.03-ны 04/2038 тоотоор ирсэн сайдын 04 дүгээр албан даалгавар.

ж) ЗТХЯ-ны ТНБД-ын 2023.10.05-ны “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 03/4716 тоот.

9/ Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, Зам тээврийн салбарын нэгдсэн платформд салбар замын мэдээлэл оруулах ажлыг тайлагнахдаа тайлант оны эхний өссөн дүнгээр бус, тухайн сард хийгдсэн ажлын хэмжээгээр тайлагнах.

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА Ц.ОЮУНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ Э.ОСОРЖАМАА